



## Эрдэнэ Ресурс Хөндий Алтны Төсөл дээр өрөмдлөгийн хөтөлбөр эхлүүлээ

Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот – 2019 оны 4 сарын 9

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь өөрийн 100% эзэмшлийн Хөндий Алтны Төслийн (цаашид “Хөндий төсөл” гэх) 2019 оны өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлж буйг мэдээлэхэд таатай байна.

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Баян Хөндийг нээн илрүүлснээс хойш гурван жилийн хугацаанд Хөндий төсөл дээр хайгуул, өрөмдлөг, нөөцийн тооцоолол ба анхан шатны эдийн засгийн тооцооллыг (“АШЭЗТ”) гүйцэтгэсэн. Харин одоо урьдчилсан ТЭЗҮ боловсруулах болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх үйл ажиллагааг эхлүүлээд байна. Дээрх өрөмдлөгийн хөтөлбөр нь өнөөгийн нөөц болон ил уурхайн хязгаарыг тэлэх, өндөр агуулга бүхий алтны бүсүүдийн үргэлжлэлийг шалгахад чиглэнэ.” “Мөн бид дундаж хэмжээтэй, ашиглалт болон хөрөнгө оруулалтын зардал бага боловч, өндөр агуулга бүхий алтны ил уурхайг хөгжүүлэхээр ажиллаж байгаа нь шинэ алтны дүүргийг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж харж байна” хэмээн танилцууллаа.

### Хөндий төслийн 2019 оны өрөмдлөгийн хөтөлбөр

2019 оны өрөмдлөгийн хөтөлбөр нь 2 үе шаттай. Нэгдүгээр үе шат нь олон улсын инженерчлэлийн байгууллага Tetra Tech, Inc.-ийн боловсруулж буй урьдчилсан ТЭЗҮ-д тусгагдах мэдээллийг баталгаажуулах, Баян Хөндий ордыг тэлэх болон өндөр агуулга бүхий нөөцийг шалгахад чиглэсэн 1,800 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр байна. Хоёрдугаар үе шат нь бүс нутгийн хайгуулд чиглэх бөгөөд энэ оны сүүлээр төлөвлөгдсөн. Нэгдүгээр үе шатны тухай дэлгэрүүлбэл:

1. Ил уурхайн хязгаарыг тэлэх: Баян Хөндийн 1 г/т захын агуулга бүхий алтны нөөцийн 30% нь АШЭЗТ дахь ил уурхайн хязгаарт багтаагүй бөгөөд үүнд 3 г/т дундаж агуулга бүхий 60,000 унц бодит, 70,000 унц боломжит нөөц агуулагдаж байна. Өрөмдлөгийн хөтөлбөрөөр уурхайн хязгаараас гадуурх өндөр агуулга бүхий нөөцийн агуулгыг нэмэгдүүлэх, үргэлжлэлийг батлах, Мидфийлд ба Хойд Мидфийлд дэх одоогийн уурхайн хязгаарыг тэлэх зорилготой. Агуулга болон үргэлжлэлийг батлан, АШЭЗТ-д тусгасан уурхайн хязгаарыг тэлснээр урьдчилсан ТЭЗҮ дэх уурхайн оновчлолыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.
2. Өндөр агуулга бүхий бүсүүдийн үргэлжлэл ба дундаж агуулгыг нэмэгдүүлэх: Анхан шатны эдийн засгийн тооцооллын нөөцийн блок загварт хамгийн өндөртөө 55 г/т алтны агуулгыг багтаасан бөгөөд Баян Хөндийн өрөмдлөгөөр 50 г/т-оос 2,200 г/т алтны агуулга

бүхий 40 гаруй интервалыг огтолсон. Эдгээр өндөр агуулгууд нь Мидфийлд, Хойд Мидфийлдийн баруун талын структуруудын уулзвар дээр байрладаг. Бидний төлөвлөсөн хэд хэдэн цооногууд нь дээрх өндөр агуулга бүхий бүсүүд болон түүнийг тэлж болох хэмжээ, агуулгын талаарх ойлголтыг өгөх юм.

3. Нөөцийг нэмэгдүүлэх: Мидфийлд болон баруун Страйкер бүсүүдийн урд ба баруун урд хэсэгт нөөцийг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд өрөмдлөгийн хөтөлбөр нь нөөцийн тооцоололд багтаагүй хэсэгт төвлөрнө. Мидфийлд бүсийн гоц өндөр агуулга бүхий интервалууд (>50 г/т алт) нь баруун хэсгээр интрузив чулуулгийг огтолсноор хязгаарласан. Энэхүү бүсүүдийг тойрон орших цооногийн үр дүнгүүд ба зүүн өмнөд хэсэгтээ үргэлжилж буйд тулгуурлан энэхүү интрузив нь тусгаарлагдсан биет байх магадлалтайг тодорхойлсон. Өрөмдлөгийн хөтөлбөрөөр Мидфийлдийн нөөцийг урагш ба баруун урд зүгт тэлэх боломжтой эсэхийг шалгана. Баруун Стайкер урьд нь хийсэн өрөмдлөгийн судалгаагаар хэд хэдэн өндөр агуулга (20-105 г/т) бүхий алтны интервалыг огтолсон. Үр дүнгүүд нь энэхүү бүсэд өндөр агуулга бүхий алт үргэлжлэх, түүнийг тэлэх боломжтойг харуулсан. Өрөмдлөгийн хөтөлбөрөөр Баруун Страйкер дахь эрдэсжилтийн үргэлжлэл болон нөөцийг нэмэгдүүлэх боломжийг шалгахаар төлөвлөсөн.
4. Газрын дөт гүнд хэтийн төлөв бүхий шинэ бүсийг илрүүлэх: Мидфийлд бүсийн өндөр агуулга бүхий интервалууд нь 50 метрийн гүнээс эхэлж байгаа боловч бүсийн зүүн хэсэгт газрын гадаргаас 20 метрт эрдэсжилт эхлэхээр загварчилсан. Мидфийлд бүс дэх өрөмдлөг нь энэхүү газрын гадаргатай ойр бүсийг шалгах, өндөр агуулга бүхий бүсийн үргэлжлэл, нөөцийн блокын хязгаар болон төлөвлөсөн уурхайн ханыг даван хийгдэхээр төлөвлөж байна. Энэхүү өрөмдлөг нь бидэнд дээр дурдсан хувьсагчдын төдийгүй Мидфийлд бүсэд хийгдэх ил уурхайн хөгжүүлэлтэд багтах нөөцийн талаар илүү дэлгэрэнгүй ойлголтыг өгөх ач холбогдолтой. Мөн баруун Страйкер бүсэд газрын дөт гүнд, алт агуулсан бүсүүдийг илрүүлсэн боловч нарийвчилсан судалгаа хийгдээгүй байсан. Өрөмдлөгийн хөтөлбөрөөр энэхүү бүсүүдийг шалгахаар төлөвлөв.

Түүнээс гадна, шинээр усны нөөц илрүүлэх хайгуулын хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд 1,375 тууш метрийн 11 цооног өрөмдөхөөр төлөвлөсөн. Хөндий Алтны Төслийн боловсруулах үйлдвэр барих байршлаас 5 км-т хангалттай усны нөөцийг илрүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино. Эдгээр хөтөлбөрийн үр дүнгүүдийг нэгтгэн Tetra Tech нь Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулахад ашиглана.

### **Хөндий алтны төслийн тухай**

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Энэхүү Төв Азийн Орогены бүс нь БНХАУ-ын нутагт хил дагуу болон бүсийн баруун чиглэлд эпитеpmаль алт болон порфирийн зэс-алтны ордууд сайн судлагдсан байдаг боловч Монгол улсын хувьд 1990-ээд оны дунд үеэс ардчилсан нийгэмд шилжин, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хайгуул хийх боломжийг олгосноор судлагдаж эхэлсэн. Ийнхүү судлагдсанаар дэлхийн хэмжээний алт-зэсийн орд болох Оюу Толгойг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардагас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна.

Компани нь 2018 оны 3-р улиралд Төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг тайлагнасан бөгөөд энэхүү тайланд 0.7 г/т захын агуулгаар тооцсон 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 751,000 унц алтны бодит нөөц, 1.8 г/т алтны дундаж агуулга бүхий 291,000 унц алтны боломжит нөөц тогтоогдсон. 2018 оны 12 сард NI 43-101 эрдсийн төслийн тайлагналын стандартын (“NI 43-101”) дагуу Анхан шатны эдийн засгийн тооцооллыг гүйцэтгэсэн. Энэхүү тооцооллоор: Алтны үнийг \$1200/унц гэж төсөөлөхөд татварын дараах өнөөгийн үнэ цэн нь (5% хоргодуулалт бүхий) (“NPV5%”) 99 сая ам.доллар, дотоод өгөөжийн хувь (“IRR”) нь 56% байсан. Мөн тооцооллоор 8 жилийн турш 3.42 г/т дундаж алтны агуулга бүхий хүдрээс жилд дунджаар 51,200 унц алт үйлдвэрлэх боломжтой уурхайг төлөвлөсөн.

## **Мэргэшсэн этгээд (геологич)**

Майкл МакДоналд (Michael A. MacDonald) нь Компанийн Хайгуул эрхэлсэн дэд ерөнхийлөгч, мэргэшсэн геосудлаач (P.Geo.) (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэ мэдээлэлд багтсан техникийн мэдээллийг хянан баталгаажуулсан болно.

## **Компанийн тухай**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн тухай тодорхой мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрэх магадлалтай тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

## **Урьдчилсан таамаглал**

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

## **Холбоо барих:**

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Кэн В. МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Емэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Вебсайт: [www.erdene.com](http://www.erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>